

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЗЭРЭГ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/16/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatarkhu@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхтулга Утас: 70432545 цахим хаяг: Munkhtulga.d@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын дамгын газар</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	төгрөгөөр5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	төгрөгөөр6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	төгрөгөөр7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	8
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	төгрөгөөр8
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа: Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	13
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	13

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цэцэрлэгийн баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433081, Факс: 976-70433081
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 2/107

тантай _____ -ны № _____ -т

ЗЭРЭГ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.ЖИГДБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зэрэг сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зэрэг сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанар зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

ТАТВАРЫН ХЭЛТСИЙН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>53,810,479.50</u>	<u>51,069,361.73</u>
33	АВЛАГА	00.00	506,784.23
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	336,386.23
335	Бусад авлага	00.00	170,398.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	170,398.00
35	БАРАА МАТЕРИАЛ	53,810,479.50	50,562,577.50
351	Түүхий эд материал	00.00	1,254,000.00
35130	Эм боох материал	00.00	1,254,000.00
354	Хангамжийн материал	53,810,479.50	49,308,577.50
35410	Бичиг хэргийн материал	239,570.00	715,000.00
35420	Аж ахуйн материал	12,216,720.00	11,404,720.00
35430	Сэлбэг хэрэгсэл	36,900.00	36,900.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	25,800.00
35450	Барилгын засварын материал	1,793,912.00	00.00
35460	Хүнсний материал	7,320,550.00	4,923,330.00
35470	Бусад хангамжийн материал	32,202,827.50	32,202,827.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>617,493,506.19</u>	<u>587,946,242.72</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	617,493,506.19	587,946,242.72
392	Биет хөрөнгө	610,101,506.19	580,554,242.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	661,359,192.70	661,359,192.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-156,853,084.41	-171,316,663.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	182,833,439.88	187,474,052.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	-98,157,584.88	-119,021,164.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,074,728.53	48,134,728.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,636,588.89	-32,877,931.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,295,387.00	15,120,387.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,479,762.00	-10,984,137.15
39217	Ном	2,665,778.26	2,665,778.26
393	Биет бус хөрөнгө	7,392,000.00	7,392,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,392,000.00	7,392,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>671,303,985.69</u>	<u>639,015,604.45</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,272,561.40</u>	<u>6,657.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,272,561.40	6,657.00
413	Өглөг	1,272,561.40	6,657.00
4136	Бусад өглөг	1,272,511.40	6,657.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,272,511.40	6,657.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>670,031,424.29</u>	<u>639,008,947.45</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	670,031,424.29	639,008,947.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	112,323,962.00	112,323,962.00
51101	Өмч: - төрийн	112,323,962.00	112,323,962.00
512	Хуримтлагдсан үр дүн	523,426,261.24	492,403,784.40
51210	Өмнөх үеийн үр дүн	523,426,261.24	523,426,261.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-31,022,476.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,281,201.05	34,281,201.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>671,303,985.69</u>	<u>639,015,604.45</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	413,184,325.00	444,832,813.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,412,625.00	407,720,813.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,412,625.00	11,605,613.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,412,625.00	11,605,613.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,412,625.00	11,605,613.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	396,115,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	396,115,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	408,771,700.00	37,112,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	408,771,700.00	37,112,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	408,771,700.00	37,112,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	442,393,239.90	475,855,289.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	442,393,239.90	475,855,289.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	442,393,239.90	457,097,985.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,936,976.00	306,520,292.00
210101	Үндсэн цалин	198,344,296.00	205,524,955.00
210102	Нэмэгдэл	62,886,977.00	100,995,337.00
210104	Урамшуулал	4,705,703.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,237,221.00	37,969,769.77
210201	Тэтгэврийн даатгал	23,520,889.00	25,711,799.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,703,360.00	3,064,493.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,164,686.00	2,451,593.00
210204	Ажилгүйдлийн даатгал	541,572.00	612,899.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,306,714.00	6,128,985.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,066,354.40	35,487,807.60
210301	Гэрэл, цахилгаан	2,710,754.40	1,300,207.60
210302	Түлш, халаалт	33,854,800.00	28,687,100.00
210303	Цэвэр, бохир ус	5,500,800.00	5,500,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,309,790.00	3,505,069.20
210401	Бичиг хэрэг	1,255,980.00	2,734,599.20
210402	Гээвэр, шатахуун	565,410.00	617,670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	137,200.00	137,300.00
210404	Ном, хэвлэл	20,000.00	15,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	949,000.00	00.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	382,200.00	00.00
2105	Нормативт зардал	53,095,940.00	28,528,820.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,200.00	1,480,200.00
210502	Хоол, хүнс	52,661,740.00	24,866,820.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	361,000.00	2,181,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,830,300.00	2,207,350.00
210604	Урсгал засвар	1,830,300.00	2,207,350.00
2107	Томилолт, зочны зардал	126,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	126,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	190,400.00	312,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190,400.00	112,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,600,258.50	42,566,876.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	280,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	506,900.00	934,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,813,358.50	41,632,876.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	18,757,304.80
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	18,757,304.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	18,757,304.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-29,208,914.90	-31,022,476.84
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	54,450.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	54,450.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-54,450.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-29,263,364.90	-31,022,476.84

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	408,771,700.00	433,227,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	396,115,200.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	396,115,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	396,115,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	408,771,700.00	37,112,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	408,771,700.00	37,112,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	408,771,700.00	37,112,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	408,771,700.00	433,227,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	408,771,700.00	433,227,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408,771,700.00	414,469,895.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,980,897.00	302,520,885.00
210101	Үндсэн цалин	185,117,601.00	170,146,145.00
210102	Нэмэгдэл	66,582,420.00	114,390,780.00
210104	Урамшуулал	15,280,876.00	17,983,960.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,203,690.00	42,475,961.00
210201	Тэтгэврийн даатгал	22,912,338.92	29,838,461.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,720,391.00	3,159,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,053,900.00	2,701,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	513,500.00	632,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,003,560.08	6,144,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,300,500.00	36,948,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,444,900.00	2,760,500.00
210302	Түлш, халаалт	34,354,800.00	28,687,100.00
210303	Цэвэр, бохир ус	5,500,800.00	5,500,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,376,113.00	1,215,099.20
210401	Бичиг хэрэг	880,700.00	124,199.20
210402	Тээвэр, шатахуун	471,000.00	639,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	121,000.00	124,800.00
210404	Ном, хэвлэл	82,700.00	78,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,820,713.00	249,000.00
2105	Нормативт зардал	57,920,000.00	26,379,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,200.00	2,734,200.00
210502	Хоол, хүнс	57,153,500.00	22,469,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	693,300.00	1,175,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	204,900.00	163,900.00
210604	Урсгал засвар	204,900.00	163,900.00
2107	Томилолт, зочны зардал	126,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	126,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	190,400.00	312,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190,400.00	112,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,469,200.00	4,454,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,139,200.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,330,000.00	4,454,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	18,757,304.80
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	18,757,304.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	18,757,304.80
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	112,323,962.00	34,281,201.05	547,609,502.14	694,214,665.19
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	738,927.00	738,927.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	112,323,962.00	34,281,201.05	548,348,429.14	694,953,592.19
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-29,263,364.90	-29,263,364.90
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	112,323,962.00	34,281,201.05	523,426,261.24	670,031,424.29
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	112,323,962.00	34,281,201.05	523,426,261.24	670,031,424.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	112,323,962.00	34,281,201.05	523,426,261.24	670,031,424.29
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-31,022,476.84	-31,022,476.84
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	112,323,962.00	34,281,201.05	492,403,784.40	639,008,947.45

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	433,227,200.00	414,469,895.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	433,227,200.00	414,469,895.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,227,200.00	414,469,895.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,419,600.00	302,520,885.00
210101	Үндсэн цалин	184,763,800.00	170,146,145.00
210102	Нэмэгдэл	102,945,500.00	114,390,780.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	20,710,300.00	17,983,960.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,651,800.00	42,475,961.00
210201	Тэтгэврийн даатгал	30,014,300.00	29,838,461.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,159,400.00	3,159,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,527,400.00	2,701,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	632,100.00	632,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,318,600.00	6,144,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,948,100.00	36,948,100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,760,500.00	2,760,500.00
210302	Түлш, халаалт	28,687,100.00	28,687,100.00
210303	Цэвэр, бохир ус	5,500,500.00	5,500,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,215,100.00	1,215,099.20
210401	Бичиг хэрэг	136,700.00	124,199.20
210402	Тээвэр, шатахуун	639,000.00	639,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	112,300.00	124,800.00
210404	Ном, хэвлэл	78,100.00	78,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	249,000.00	249,000.00
2105	Нормативт зардал	37,641,200.00	26,379,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,734,200.00	2,734,200.00
210502	Хоол, хүнс	33,808,100.00	22,469,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,098,900.00	1,175,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	163,900.00	163,900.00

210604	Урсгал засвар	163,900.00	204,900.00
2107	Томилолт, зочны зардал	141,600.00	00.00
210702	Дотоод албан томилолт	141,600.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	343,600.00	312,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.00	112,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5702300.00	4454200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,702,300.00	4,454,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	433,227,200.00	414,469,895.20
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	396,115,200.00	377,357,895.20
131001	Улсын төсвөөс санхүүжих	396,115,200.00	377,357,895.20
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,112,000.00	37,112,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	37,112,000.00	37,112,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28	28
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17
620003	Үйлчлэх ажилтан	10	10

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Зэрэг сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Ц.Жигдбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд "Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино" гэж заасны дагуу "Нутаг дэвсгэртээ сургуулийн өмнөх боловсролыг чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх" зорилтыг дэвшүүлж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Зэрэг сумын цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 413184.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4131.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 444832.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4448.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зэрэг сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32288.38 мянган төгрөгөөр буюу 5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Авлага	0.00	506.78	506.78	100%
Бараа материал	53,810.48	50,562.58	-3,247.90	-6%
Үндсэн хөрөнгө	617,493.50	587,946.24	-29,547.26	-5%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	671,303.98	639,015.60	-32,288.38	-5%
Богино хугацаат өр төлбөр	1272.56	6.65	-1,265.91	-99%
Цэвэр хөрөнгө, өмч	670,031.42	639,008.95	-31,022.47	-5%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	671,303.98	639,015.60	-32,288.38	-5%

Авлага данс оны эцэст 506.78 мянган төгрөг болж 506.78 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 336.38 мянган төгрөгөөр, үйлдвэрчний эвлэлийн авлага 170.4 мянган төгрөг болсонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 50562.58 мянган төгрөг болж 3247.9 мянган төгрөгөөр буурсан нь тайланд онд 30166.74 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 33414.64 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 671303.98 мянган төгрөг, оны эцэст 369015.60 мянган төгрөгөөр болж 32288.38 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 7895.61, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 4160.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж аймгийн ИТХ-ын тогтоолоор 1560.0 мянган төгрөгийн хөрөнгийг Зэрэг сумын сургуульд шилжүүлжээ.

Тайлант оны элэгдлийн зардал 41632.87 мянган төгрөг байгаа нь үндсэн хөрөнгийн бууралтад нөлөөлжээ.

Өглөг дансны үлдэгдэл 6.65 мянган төгрөг болж 1265.91 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд гэрэл цахилгааны өглөгийг төлж барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 639008.95 мянган төгрөг болж тайлант онд 31002.47 мянган төгрөгөөр буурсан байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Зэрэг сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 31648.49 мянган төгрөгөөр буюу 7.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 31648.49 мянган төгрөгийн орлогоос 24455.8 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 7192.99 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 33462.0 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 44315.6 мянган төгрөг буюу 14.7 хувиар, хангамж бараа материалын зардал 195.3 мянган төгрөг буюу 5.9 хувиар, урсгал засварын зардал 377.0 мянган төгрөг буюу 20.6 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 121.6 мянган төгрөг буюу 63.8 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 966.6 мянган төгрөг буюу 2.3 хувиар, урсгал шилжүүлэг 17757.3 мянган төгрөг буюу 100 хувиар өссөн, тогтмол зардал 6578.5 мянган төгрөг буюу 15.6 хувиар, нормативд зардал 24567.1 мянган төгрөг буюу 46.5 хувиар, томилолтын зардал 126.0 мянган төгрөг буюу 100 хувиар буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор сургалтын үйл ажиллагаа түр хугацаагаар хаагдсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 433227.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 433227.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 12/02 тоот тогтоолоор Цэцэрлэгийн 2020 оны төсвийг 433227.2 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 433227.2 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 37112.0 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 396115.2 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 396115.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 37112.0 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 433227.2 мянган төгрөгийн бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 414469.9 мянган төгрөгийг зарцуулж 18757.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 414469,9 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь хангамж бараа материалын зардлыг мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг мянган төгрөгөөр тус тус хэтэрч зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 18757.3 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой томилолтын зардал, хог хаягдал орчны бохирдлын арга хэмжээний зарцуулах эрхийг нээж өгөөгүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	173.2
81807	Хүүхдийн хоол	11338.5
81832	Нүүдлийн бүлэг	902.4
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	3370.0
80109	Тогтмол зардал	
81831	Ээлжийн бүлэг	2973.2
	ДҮН	18757.3

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт дансаар 2020 онд орлого болон зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 137, хугацаа хоцроож мэдээлсэн 11 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд санхүүжилтийн мэдээллийг байсныг аудитын явцад залруулж мэдээлүүллээ.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллага нь Итгэл авсан тул ямар нэгэн алдаа зөрчил бүртгэгдээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 1 алдаа зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 1 алдаа зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлтэй холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Тайлант онд гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

1.2. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

1.3. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Зэрэг сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/16/СТА-ТШЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Зэрэг сумын цэцэрлэг

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	И баримтаар нотлогдоогүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн.	0	Зөвлөмж	Эрхлэгч, Нягтлан бодогч	Ц.Жигдбаяр Б.Сарангэрэл
ДҮН		0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР